



МОНГОЛЫН НИЙТЛЭЛЧДИЙН АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ ДЭХ БНХАУ-ЫН ИМИЖ

У. Мандаа*, Б. Наранбаатар**

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн докторант*

***МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн эрхлэгч, дэд профессор, доктор (Ph.D.)*

Түлхүүр үгс: улс орны имиж, аян замын тэмдэглэл, БНХАУ, Монголын хэвлэл мэдээлэл, контент шинжилгээ, 4D загвар

Оршил: Аян замын тэмдэглэл нь сэтгүүл зүйн хамгийн эртний бөгөөд баялаг бичлэгийн төрөл зүйл байсаар ирсэн бөгөөд дэлхий дахинд аялал жуулчлал, хэвлэл мэдээллийн салбар, технологийн хөгжлийг даган улам баяжиж байна. Монголын өдөр тутмын сонин болон вэб сайт, блогуудад гарсан аян замын тэмдэглэлийн тал нь гаднын улс орнуудын тухай бөгөөд үүнд Хятадын тухай тэмдэглэлүүд давамгайл байр суурь эзэлдэг байна. 1990 оноос хоёр улсын гадаад харилцаа нээлттэй болж, шинэ шатанд гарсан. Улс орны имиж нь олон улсын харилцаа болон зөөлөн хүчний бодлогоор дамжин бүрэлддэг цогц ойлголт бөгөөд хэвлэл мэдээлэл түүнийг бүтээх, дамжуулахад чухал үүрэгтэй (Anholt, 2010). Монголын хэвлэл мэдээлэл БНХАУ-ын тухай аян замын тэмдэглэл тогтмол нийтлэгдэж ирсэн хэдий ч эдгээр бүтээлүүд дэх Хятад улсын болон хятад хүний имижийг системтэй судалсан эмпирик судалгаа хомс байна.

Иймээс энэхүү өгүүлэл нь Монголын өдөр тутмын сонин болон онлайн хэвлэлд нийтлэгдсэн аян замын тэмдэглэлүүдэд БНХАУ-ын имиж хэрхэн бүрэлдэж буйг тодорхойлох зорилгоор хийгдэв.

China's Image in The Travelogues of Mongolian Journalists. **Manda (MA),
Naranbaatar.B (Ph.D.)**

Арга зүй: Судалгаанд 1992–2024 оны хооронд Монголын өдөр тутмын сонин (48) болон онлайн мэдээллийн хэрэгсэлд (47) нийтлэгдсэн нийт 95 аян замын тэмдэглэлийг хамруулсан. Судалгааны арга зүйд агуулгын шинжилгээ, сентимент шинжилгээ, улс орны имижийг тодорхойлох 4D загварыг ашиглав. Агуулгын шинжилгээгээр Хятад улс болон хятад хүний талаарх дүрслэл, үнэлэмжийг кодлон ангилсан бол сентимент шинжилгээгээр зохиогчийн хандлагыг эерэг, сөрөг, төв гэж бүлэглэв. 4D загвараар үүргийн, норматив, гоо зүйн, сэтгэл хөдлөлийн хэмжээсийг задлан шинжилсэн.

Монгол нийтлэлчдийн бичсэн Хятадын тухай аян замын тэмдэглэл дэх БНХАУ-ын имижийг тодорхойлохдоо бид өдөр тутмын сонины 48, онлайн хэвлэн нийтлэгчдийн 47, нийт 95 бүтээл хамруулсан. Монгол сэтгүүлч, нийтлэлчдийн бичсэн аян замын тэмдэглэлүүд дэх Хятад улсын имижийг тодруулахдаа дараах аргуудыг ашигласан. Үүнд,

Хятад улс болон хятад хүний тухай тодорхойлолтод хийсэн агуулгын шинжилгээ

Зохиогчийн хандлага, байр суурийн сентимент шинжилгээ

Улс орны имижийн 4D загвар.

Хэлэлцүүлэг, үр дүн: **Хятад хүний имиж.** Аян замын тэмдэглэлд очсон газрынхаа төрх байдлыг дүрслэн тайлбарлахаас гадна тухайн орны ард түмний аж амьдралыг уншигчдад танилцуулах нь чухал байдаг. Өөр улс орны хүмүүс хэрхэн аж төрж буй нь үеийн үед анхаарал татсан сэдэв байсаар ирсэн. Тухайн хүний гадаад төрх, зан байдал, үйлдэл, хэлж буй үгээр нь улс орных нь иргэдийн нийтлэг байдлыг төлөөлүүлдэг. Судалгаанд хамруулсан аян замын тэмдэглэлүүдэд Хятадад уулзсан хүнээ тодорхойлсон, тайлбарласан, үнэлж дүгнэсэн нь таамагласнаас цөөн байсан. Мөн тухайн орны хүнтэй ярилцаж, мэдээлэл авах нь бага байв. Нийт 95 аян замын тэмдэглэлийн 33.6 хувь буюу 32-т нь тухайн улс орны иргэн 43 хүнийг ямар нэг байдлаар дурджээ. Үүнээс хамгийн олон хүнийг дурдсан нь “Өдрийн сонин”-ы 2004 оны 10-р сарын №266, 267-д нийтлэгдсэн “Далд Түвдийн далласан газар” байв. Ж.Гангаа Төвөдийн өөртөө засах орны нийслэл Лхас хотод очиж, Хималайн нурууны Жамалунгма оргилд гарсан аян замдаа тааралдсан төвөд мөргөлчин, хятад орчуулагч, монгол зохиолч нартай хөөрөлдсөнөө бичсэн. Мөн “нэг эмэгтэй”, “нэг эрэгтэй” гэх зэргээр ерөнхий байдлаар дурдсан байдаг. Уг цуврал аян замын тэмдэглэлийг бүхэлд нь авч үзвэл нийт 8 хүнийг дурдаж, заримыг нь эх сурвалжаа болгосон нь тухайн газар орны байр байдал, хүмүүсийн аж амьдралыг бодитоор нээн харуулахад чухал баримт болжээ. Харин бусад

аян замын тэмдэглэлүүдэд ихэнхдээ нэг л хүнийг дурдах эсвэл мэдээллийн эх сурвалж болгон бичсэн. Мөн өдөр тутмын сонинтой харьцуулахад онлайнд нийтлэгдсэн тэмдэглэлүүдэд хүн дурдах, эх сурвалж болгон мэдээлэл авах нь эрс бага байв. Онлайн нийтлэлчдийн 48 тэмдэглэлийн 8-д нь л тухайн орны хүмүүсийг ямар нэг байдлаар дурдсан нь эх сурвалжийн хувьд дутагдалтай байлаа.

Хүйсийн хувьд эрэгтэйчүүдийг дурдах нь түгээмэл байв. Дээрх тэмдэглэлүүд дурдагдсан хүмүүсийн 13 нь л эмэгтэй, 32 нь эрэгтэй байсан. Онцлон дурдсан эмэгтэйчүүдийн олонх нь очсон айлын эхнэр, аяллын хөтөч, эсвэл тухайн газар орны түүхийг өгүүлэх өндөр настан байсан. Харин түүхэн хүн өндөр албан тушаалтан, мэргэжилтэн, амжилт гаргасан эрэгтэйчүүдийг дурдах, эх сурвалж болгох нь түгээмэл байв. Энэ нь зохиогчийн сонголт гэхээс илүү өндөр албан тушаал, чухал ажил албанд эрэгтэйчүүд голлох байр суурьтай байдаг Азийн соёлтой холбоотой байх магадлалтай.

Аян замын тэмдэглэлүүдэд дурдсан хүмүүсийн мэдээллийг нэн товч өгүүлэх бөгөөд ихэвчлэн тухайн газар орон, болж буй үйл явдлын талаар мэдээлэл өгч буй байдлаар дүрслэн үзүүлдэг байна. Ерөнхийд нь авч үзвэл эмэгтэйчүүдийг энгийн аж байдалтайгаар, эрэгтэйчүүдийг, ажил албаа хийж яваа байдлаар эдгээр аян замын тэмдэглэлүүдэд харуулжээ. Гэхдээ үүнийг улс орны ард иргэдийн талаар мэдээлэл бага байсан гэж үзэж боломгүй, хятад орны иргэдийг нийтээр нь ерөнхийлөн тодорхойлсон аян замын тэмдэглэлүүдэд мөн байсан. Хятад хүнийг ерөнхийд нь дүрслэн тодорхойлсон нийт 13 тэмдэглэл олдсон бөгөөд үүнд “ухаантай, урт насалдаг, найрсаг, даруу, ажилсаг, зохион байгуулалт сайтай, сэргэлэн, цэвэрхэн, соёлтой, загварлаг, хатуужилтай” зэрэг тэмдэг нэр ашиглан тодорхойлон бичжээ.

“Буман лагшинг түвд оронд зорчихуй” (baabar.mn, Д.Сүхбаатар, 2008) тэмдэглэлд Эрээн, Хөх хот, Бээжин, Ланжоу, Шинийн хотоор дамжин Лхас очсон тухай бичсэн. Уг тэмдэглэлд “...Автобусаар зорчиж буй, гудамжаар явж буй Бээжин хотын хятад хүмүүс нь даруухан, хувцаслалт нь энгийн байлаа. Согтуу, хэрэлдсэн хятад хүн алга. ...Гүмбүм хаана байдаг вэ?” хэмээн асуухад тэр эмэгтэй биднийг нэгэн автобусанд суулгаж өгөөд бидний өмнөөс 16 юань төлөөд хаана буулгахыг нь хүртэл автобусны жолоочид захиж хэлээд явуулж билээ. Ямар сайхан сэтгэлтэй бүсгүй бэ? Хятад бүсгүйчүүд хүнд их тусархуу ажээ” хэмээжээ. Бүр 1999 онд “Үнэн” сонины “Зян Зэмийн төрсөн нутаг Янжоуд зорчсон тэмдэглэл”-д “Харин хятад хүмүүс хаана ч хэнтэй ч зохицоод амьдарч чадаад байдаг нь гайхалтай. Хятад хүн суудаггүй улс орон, хот гэж дэлхийд үгүй биз ээ. Ямартаа л хятад хүний толгой дээр нар шингэдэггүй гэсэн үг

гарч байх вэ” гэсэн бол 2012 онд “Өнөөдөр” сонинд гарсан Х.Одончимэгийн Сычуань мужаар аялсан цуврал тэмдэглэлд “Хөл тасардаггүй, «шөнө болдоггүй» гэрэлт гудамжаар яарсан, адгасан, хөмсөг зангидсан хүнтэй таараагүйдээ яагаад ч юм гайхлаа. Тайван, аядуу, сэтгэл хангалуун, магадгүй өнөөдрөөрөө амьдарч байгаа гэмээр мянга мянган хүний царайд тэмүүлэл, ирээдүй тодорч байх шиг санагдсан... Улс орны хөгжлийг эдийн засгийн үзүүлэлтээр хэмжихээс илүү хүмүүсийн царайд тодорсон тэр өөдрөг гэрлээр л тодорхойлчихож болох мэт” гэх мэтээр тодорхойлсон байна.

Харин өвөрмонголчуудын тухайд тодорхойлсон 3 тэмдэглэлд “хариуцлагатай, ажилсаг, эелдэг, найрсаг, архи уудаг” гэжээ. Төвөдүүдийн тухайн 7 аян замын тэмдэглэл байсан бөгөөд “дээрэнгүй, худалч, хулгайч, бохир, хоцрогдсон, мухар сүсэгтэй, гэнэн цайлган, гүжир хажир, омголон цовоо” зэргээр тодорхойлон бичжээ. Ж.Гангаагийн “Далд түвдийн далласан газар” (“Өдрийн сонин”, 2004) аян замын тэмдэглэлд “Түвд авгайг нялх хүүхдээр нь багцаалахад уг нь залуухан бүсгүй шиг бололтой. Шуурга сөрөн зүтгэж буй мэт шаналгаатай бор царайтай боловч нүд нь хутга мэт хурц гялалзана... Сайртай хөл гар нь сарвайсан бяцхан хүү эхийнхээ ард нугжийн унтсан байв. Харин хүүг тэврэх ёстой хүүхний хоёр гарны нэгэнд нь урт эрхи, нөгөөд нь хүрд эргэлдээд тун завгүй. Хүн ингэж бурхныг шүтэж буян хураадаг юм байна.. Халуунд даахирч хирэндээ баригдсан үсийг нь дагаад шанаа руу нь хөлс цувж байлаа. Духных нь эвэр тэднийг улам ч сүрлэг, эршүүд терхтэй болгосон мэт. Бүгдийнх нь ширэн хормогч өвдөгний ойр орчимдоо цоорч, хувцас нь элж гандсан нь бид хэцүү зам туулсан шүү гэж хэлээгүй байхад нь ч ойлгогдож байлаа. ... Хир даг болсон хувцас, духных нь эвэр, даахирсан үс. Энэ бүх эрээн бараанд үл дарагдах гялалзсан цоглог нүд. Тэдний энэ төрх олон сар өнгөрсөн ч мартагдаагүй л байна. Хүссэн зорилгодоо хүрэхээр ийн хатуу ширүүн, халуун хүйтэн, хоол, нойрыг умартан зүтгэх нь бахархмаар ч юм шиг.


...Ингэж итгэж биширч, шүтэж, бурхандаа унаж мөргөн олон сарын замыг туулсан хүмүүст бүхнээ бурхандаа өргөх юу ч биш. Амиа өргөх нь ч юу ч биш. Шуналгүй байх, сэтгэл тайван амгалан байхын жаргалыг тэндээс олдог. Тэд бурхан шигээ амгалан амьдардаг” хэмээн тодорхойлсон. 2004 “Өнөөдөр” сонинд С.Батбаатар “Хаан уулсын эцэг, хатан мөрний ижий нутаг” тэмдэглэлд “Эндээс явахдаа би төвд хүнийг морин дэл дээр ханхалзсан, урт бүс, том ташууртай, мөрөө давсан үс, ташаагаа дарсан том хутгатай сүрлэг эрээр төсөөлж явлаа. Том жижиг хутга, ширэлдэж дагь болсон ус хоёр нь байна аа. Харин морь унасан төвдийг харсангүй... Насаар надтай ойролцоо энэ эр хоцрогдол, бохирдлын туйл болсон бүдүүлэг

орчиндоо хэр удаан амьдарч, хэдийд мөнгөнөөс бусдыг боддог болох бол оо гэсэн гунигт бодол тэдний хараад хараад үл ойлгогдох хачин арзгар юмаар дүүргэсэн хаяанд нь Хэвтээ өрөөсөн хятад шаахайтай хаягдлаа... Төвдүүд хоцрогдсон ч гэгээн, цайлган ард түмэн. Иймээс тэднийг жаргалтай хувь заяа тосож байгаа нь лавтай.

...Жинхэнэ төвд хүнийг ёстой л «онгон байгалийн зэрлэг амьтан» гэлтэй. Гүжир хажир, омголон цовоо дүр төрх араас нь ч урдаас нь ч гэрэлтэх. Алга тоссон гуйлгачин, алт өвөрлөсөн баян хоёрын аль алиных нь нүд яг адил очтой...” гэх зэргээр бичсэн байна. Гэхдээ төвөдүүдийн тухай бичсэн аян замын тэмдэглэлүүдийн ихэнх нь он цагийн хувьд 20 орчим жилийн өмнө бичигдсэн бөгөөд тухайн үеийн хүмүүсийн имиж, аж байдлыг л харуулсан гэдгийг анзаарах нь зүйтэй.

Хятад орны имиж. Монголын сэтгүүлч, хэвлэн нийтлэгчдийн бичсэн аян замын тэмдэглэл дэх имижийг тодруулан судлахдаа зохиогчийн эерэг, сөрөг, төв (neutral) байр суурийн алинаас бичсэн болохыг шинжилсэн сентимент судалгаа хийсэн. Ингэхэд Хятадын тухай аян замын тэмдэглэлүүдийн төвийг сахисан нь 62 буюу 65.2 хувь, эерэг нь 27 буюу 28.4 хувь, сөрөг нь 6 буюу 6.3 хувь байв. Хэрэгслээр нь задалж харвал веб сайтад сөрөг хандлагтай тэмдэглэлийн тоо илүү байсан.

График 1. Хятадын тухай нийт аян замын тэмдэглэлийн зохиогчийн хандлага, тоогоор.




Хятадын тухай аян замын тэмдэглэлүүдэд хэдийгээр сайшаан магтсан зүйл олон боловч шүүмжилсэн жишээ мөн тааралдана. Сонин болон онлайн нийтлэлүүдийн хувьд сайшаан магтсан, шүүмжилсэн жишээ, тэдгээрийн хэмжээний хувьд дараах байдалтай байна. Бид аян замын тэмдэглэлүүдэд сайшааж эсвэл шүүмжлэн бичсэн жишээг түүн жагсаасан болно. Ингэхэд сайшаасан жишээ 135, шүүмжилсэн жишээ 34 байв.

Зохиогчид ихэндээ Хятад орны олон хүн бужигнасан, зай завсаргүй

барьсан өндөр барилгууд, давчуу бөгчим байдлыг шүүмжилжээ. Ц.Сүрэнжавын “Шандуйгийн шар тал” (Үнэн, 1999)-д “Тариачид ургацаа улсад ид тушааж байгаа болохоор хөл хөдөлгөөн гэдэг даанч яв даа гэмээр их” хэмээн халаглаж байсан бол “Өдрийн сонин”-д 2002 онд бичсэн Ш.Цэрэнпилийн Хөх хот, Шэньжэнь, Хонконг, Бээжин хотоор аялсан “Хэмнэл ба нүргээн”-д “Тэнгэр баганадсан өндөр барилга, уул толгод болон далайн хүзүүвчийг доогуур нь нүхлэн тавьсан зам харгуй нь юмыг хэрхэн хийж бүтээж чаддагаа үзүүлж гайхуулах мэт санагдана.

График 2. Зохиогчийн сайшаасан, шүүмжилсэн байдал.



Цавчим уулын хажилга налуу дээр донжийлгож, дэнжийлгэн босгосон олон арван давхар барилга хэзээ нураад дээрээс дарчих бол гэх сэтгэгдэл байнга төрүүлнэ. Ерөөс эндхийн нарийн бачим гудам жууд, түүнийг шахаж хүрээлсэн өндөр барилгууд дотор цээжийг бачууруулах юм” гэж бичсэн нь бий. Ялангуяа замын хөдөлгөөн нь ойлгомжгүй, төвөгтэй гэдгийг хэд хэдэн тэмдэглэлд дурдсан. Мөн зарим аяллын компани нь үйлчилгээ муутай, аль болох мөнгө авахыг боддог, худалдаа наймаандаа харамч нарийн байдгийг шүүмжилсэн. Түүнчлэн улс орны хувьд цагаачлалын бодлого, мэдээллийн хувьд хаагдмал гэдгийг жишээгээр тайлбарлан онцолжээ. 2017 онд Unread.today.mn-д Батзаяагийн бичсэн “Хятадын инновацийн хөгжил буюу бээжин, гуанжоу, шэнжэн хотуудаар аялсан тэмдэглэл”-д “Лавшруулан бодвоос гадны, тэр дундаа Америкийн Цахиурын хөндий, шилдэг энтрепренер, компаниудын амжилтын түүх, намтар, мөн зарим төрлийн уран зохиолыг Хятадад хаачихсан аж. Гадны нөлөөнд хэт автаж, жишээлбэл АНУ-ыг хэт мундаг гэж бодох боломжийг хааж, оронд нь өөрийн уран зохиол, амжилтын түүхүүдийг хүмүүстээ уншуулахыг зорьж байгаа нь илт. Буруутгахад бас хэцүү юм. Тэрбум гаруй хүнийг бас ингэж байж л чиглүүлдэг буй заа” гэжээ. Мөн 2023 онд ergelt.mn сайтад нийтлэгдсэн Н.Отгонбаатарын аян замын тэмдэглэлд Өвөрмонголын Хайлаар хотоор аялсан тухайгаа бичихдээ “Гэхдээ хотод нь монголчууд нүүдэлчид биш, хятадууд амьдарч байгаа нь нэг л зохимжгүй санагдана. Ёстой нэг дүр эсгэсэн монгол хот гэвэл Хайлаар хотыг хэлэх байх... Хятадын орон нутаг дотор хотоос хот

руу зорчиход ахиад л улсын хил давж байгаа мэт гаалийн хатуу чанга үзлэг, хяналт, шалгалтыг даван туулах юм. Алхам тутамд цэрэг, цагдаагийн хувцастай, гав, бороохой, гар буу зүүсэн хүмүүстэй таарах нь жихүүдэс төрөм, ая тухгүй мэдрэмж төрүүлнэ...Гэхдээ Хятадын хөгжлийн сүүдэртэй тал нь мэдээж үндэсний цөөнхийг хавчиж, цөөрүүлэх, оршин тогтнох нөхцөлийг нь багасгах, хүний эрх чөлөөг хумих бодлого нь аюул дагуулж байгаа билээ” хэмээжээ. Онлайн нийтлэлчдийн хувьд ихэнхдээ өөрсдийн дураар аялдаг, хэн нэгэнд тайлагнах шаардлагагүй учир илүү чөлөөтэй бичиж буй байдал энэ мэт эрс шүүмжлэлүүдээс харагдаж байлаа.

Эх сурвалж ашигласан байдлын хувьд өдөр тутмын сонинд ч онлайн мэдээллийн хэрэгслүүдэд ч сул байсан. Өдөр тутмын сонинд гарсан 47 тэмдэглэлд нийтдээ 28 эх сурвалжаас товч мэдээлэл, тодруулга авсан бөгөөд үүний 22 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй. Харин мэдээллийн вэб сайт, блогуудад гарсан аян замын тэмдэглэлүүдэд 9 мэдээллийн эх сурвалж ашигласний 6 нь эрэгтэй, 3 нь эмэгтэй байв. Мэдээлэл авсан эх сурвалжийн нэрийг бичсэн нь тун ховор бөгөөд ихэнхдээ “нэг эрэгтэй”, “нэг эмэгтэй” гэх зэргээр хэт ерөнхийлөн бичих нь олон тааралдсан болно.

Ер нь Хятадын тухай аян замын тэмдэглэлүүд сэдэв, очсон газраа дагаад танин мэдэхүйн шинж чанар давамгайлж ажиглагдаж байлаа. Өдөр тутмын сонинуудын хувьд сэтгүүл зүйн мэргэжлийн байгууллага гэдэг утгаараа улс орны нарийн, эмзэг сэдвийг хөндөх, эрс шүүмжлэхээс татгалзсан өнгө аяс ажиглагдаж байлаа. Мөн олон талын эх сурвалжаас мэдээлэл авч, түүнийгээ задлан шинжилж, дүгнэсэн аналитик шинж чанар нэн сул байв. Ихэнхдээ очсон газрынхаа үүх түүхийг өгүүлснээр эхэлж, өнөөгийн нөхцөл байдлыг баримтаар нотлоод Монголтой харьцуулсан ажиглалт, үнэлэлт дүгнэлтээр төгсөх зохиомж уламжлагдсаар байна. 1992 оноос хойших хугацаанд агуулга, сэдвийн хувьд төдийлөн их өөрчлөлт гараагүй. Харин хэлбэрийн хувьд мэдээллийн багтаамж нь илүү сайжирсан нь аян замын тэмдэглэлүүдээс ажиглагдсан юм.

Аян замын тэмдэглэлүүдэд Хятад орныг бүхлээр нь тодорхойлох нь цөөн, харин очсон хотынхоо янз байдлыг тодорхойлон бичих нь олон байсан. Ийм тодорхойлолт нийт аян замын тэмдэглэлийн 17.5 хувь буюу 19-д нь тааралдсан бөгөөд “баян, хууль нь хатуу, цэвэрхэн, тайван, өндөр барилгатай, зохион байгуулалттай, үзэмжтэй” хэмээн бичжээ.

Монголчууд хөрш орныхоо тухай тайлбарлан бичихдээ ихэвчлэн Монгол оронтой харьцуулах нь түгээмэл ажээ. Ийм харьцуулалт 42-т нь буюу 44.2 хувьд нь байгаа нь цаг хугацааны хувьд ялгаагүй, уламжлагдсан шинжтэй байна. Эдгээр харьцуулалт нь нэг бол монголчуудын мэддэг газар оронтой харьцуулж тайлбарласан (Тань Ань Минт талбайг Сүхбаатарын

талбай, Шар мөрнийг Орхон, Туултай харьцуулах гэх мэт) танин мэдэхүйн шинжтэй, нөгөө бол монголчууд бас ингэж хөгжих хэрэгтэй гэсэн санааг агуулж байна.

2002 онд Д.Сайнбаярын “Өнөөдөр” сонинд нийтэлсэн “Өвөр монголын өнө эртний түүх” тэмдэглэлд “Хөх хот хэд хэдэн хурдны замтай. Бүр атаархмаар. Манай Улаанбаатар хэзээ ийм болно доо гэж бид ярьж явлаа. Хөх хотоос Чингисийн онгон хүртэл 400-гаад километр. Засмал зам тавиагүй байхад энд хонон өнжин байж хүрдэг байж. Бид ердөө гурван цаг гаруйхан яваад л хүрчихлээ. Хятад хүн машинаа бус замаа засдаг гэж сонссон юм. Учир нь хичнээн сайхан машин байгаад муу замтай бол дороо эвдэрдэг, дуу чимээтэй болдог гэдэг. Үүнийг манайхан ч сайн мэднэ л дээ. Замаа засдаг гэдэг нь үнэн юм. Гэхдээ тэдэнд нөхөөсний тухай ойлголт байхгүй. Манайд бол ноднин тавьсан шинэ замынхаа нэг хэсгийг энэ жил нөхдөг. Түүнийгээ дараагийн жил дахиад л нөхдөг. Шинээр нэг километр зам тавьчих хөрөнгөөр 100 метрийн нөхөөс л хийгээд байх. Хотын дарга нар маань энэ байдлаа харьцуулж харсан байх аа” хэмээн бичиж байжээ.

2012 онд Х.Цэвлээгийн “Үнэн” сонинд нийтэлсэн “Бээжин нугас биед шингэж, шанхайн убодол санаанд хургав” нийтлэлд “Шанхайн хүмүүс Монголчуудыг бодвол урт насалдаг, Хятадад 100 хүн тутмын 1.7 нь ядуу, Монголд 100 хүн тутмын 30 нь ядуу, Хятадын төр ард түмэндээ ажиллаж чадаж байна. Манайх бас ийм байвал сайн сан”, 2024 онд “Өнөөдөр” сонины сэтгүүлч Г.Цолмонгийн Шинь Аньд аялсан тэмдэглэлд “Ши Ань хот шөнийн гудамжаа Тан гүрний нойргүй хот хэмээн нэрийдэх аж. Манай нийс лэлийн хуучнаар Хүүхдийн 100 дахь шөнийн гудамж гэж хэлж болохуйц. Гэхдээ нөхцөл байдлын хувьд өдөр, шөнө шиг ялгаатай. Улаанбаатарын шөнийн гудамжны амьдрал бол автомашины түгжрэл, согтуу хөлчүү залуусын орилоон, энд тэнд нус, цэрээ хаясан, зарим тохиолдолд “морь харсан” хүнтэй ч таардаг. Тан гүрний нойргүй хот бол бидний мэдэх Тансан ламын баруун этгээдэд зорчихдоо залсан ном бүхий Да Яньта суваргаас эхлэн 2.1 км үргэлжилсэн, 500 метр өргөнтэй гудамжнаа оршино. Энэ гудамж үнэхээр л хүмүүс нь унтдаггүй юм уу гэлтэй шөнө болтол олны хөлд дарагдаж байдаг аж. Хэд хэдэн газарт зассан тайзнаа дуучид, бүжигчид уран бүтээлээ толилууулж, гудамж дагуух түргэн хоолны газрууд үйлчлүүлэгч олонтой байх юм” зэргээр Хятадын хөгжлийн давуу талыг Монголынхтой харьцуулж бичдэг онцлог ажиглагдлаа.

Ер нь монгол нийтлэлчдийн голлон эрж хайж буй, онцлон бичиж буй санаа нь Хятад улс орон юугаараа Монголтой төстэй бөгөөд ялгаатайг жишээгээр тайлбарлан бичих явдал байна. Аян замын тэмдэглэлүүдийн олонх нь албан томилолт ажлын шугамаар явж буй учраас хөтөч нар нь томоохон үйлдвэр, худалдааны байгууллагуудад урьдаг. Нийт тэмдэглэлийн

45 нь буюу бараг талд нь Хятад орны өнөөгийн хөгжлийн гол онцлогийг тодорхойлсон бөгөөд үүнд хотын бүтээн байгуулалт, үйлдвэржилт, зам, аялал жуулчлалын хөгжлийг онцгойлон дурджээ. Мөн ард иргэд нь баян чинээлэг, эрүүл чийрэг, интернэт технологийн хувьд хөгжиж буй талаар дурдсан нь ч байна. Харин Өвөрмонголын тухайд сүүлийн жилүүдэд хотын бүтээн байгуулалт нь эрс сайжирч, бэлчээрийн менежмент нь сайжирч буй талаар онцлон бичжээ.

“Үнэн” сонинд 2002 онд нийтэлсэн Л.Эрдэнэмаагийн “Бохайн эргийн сувд буюу тэнгэрийн зам” Тянь Жинь хотод аялсан тухай тэмдэглэлд “Бээжингээс Тэнгэрийн зам хүртэл 120 км. Хурдны замаар хоёр цаг гаруй л явна. Өмнө нь гурван цаг гаруй давхидаг байж. Харин 1995 онд хурдны замтай болсноор бүтэн нэг цагийг хэмнэж чаджээ, Тянь-Жана Бээжингээс илүү өөрийн хэв мангаа хадгалж чадсан хот шиг санагдсан... Тэгээд ч аж үйлдвэр, худалдааны хот болох нь алхам тутамд тодорно. Хотын хаана л бол хаана барьж буй ондөр өндөр барилгууд бас зар сурталчилгааны самбарууд Бараг нэг км хэртэй үргэлжилнэ. Тянь- Жинь гурван хэмжээст ачаа тээвэрлэлтийн сүлжээ гэж байдаг. Энэ нь далайн болон төмөр зам, хурдны зам аж. Үсрэнгүй хөгжилтэй хотын захаар хааяахан троллейбус явж байх нь сонин харагдсан...100 мянган тонны багтаамжтай гүн усны сувгийг ашиглалтад оруулах юм байна. Ингэснээр дөрвөн сая чингэлэг буюу 120 сая тонн бараа бүтээгдэхүүн тээвэрлэх чадалтай болох аж...Хятадын үүрэн телефоны хөгжлийн тухай энд дурдахгүй өнгөрөмгүй. Өнөөдөр тус улсын 12 хүнд нэг гар утас ногдож байна” гэсэн нь нийтлэг жишээ болж байна. Тодруулбал, Хятад орны өсөлт хөгжилтыг онцлон бичээгүй аян замын тэмдэглэл үгүй аж.

Хятадын улсын имижийг тодорхойлохдоо 4D загварыг ашигласан. Энэхүү загварын дөрвөн хэмжээсийн дагуу тодорхойлсон жишээнүүдийг ангилан тоолсон. Энэ загвар нь тухайн улс орны тухай агуулгыг үүргийн хэмжээс, норматив хэмжээс, гоо зүйн хэмжээс, сэтгэл хөдлөлийн хэмжээс гэсэн дөрвөн хэсэгт ангилж, бүлэг бүрт оногдох хамгийн олон давтагдаж буй агуулгыг тоолж судалдаг. Энэхүү судалгаанд 95 аян замын тэмдэглэл дэх Хятад улс оронтой холбоотой тодорхойлолт, жишээ, сэтгэгдлүүдийг түүж, түүнийгээ агуулгаар нь ангилсан. Тодруулбал, нийт 95 аян замын тэмдэглэлийн 370 (давхардсан тоогоор) жишээ, агуулгад задлан шинжилгээ хийлээ.

1.Үүргийн хэмжээс (Functional dimension) нь тухайн улс орны тухайн орны улс орны чадавх, өрсөлдөх чадварын талаарх тодорхой итгэл үнэмшил, улс төр, эдийн засгийн үр ашиг, гүйцэтгэлийн талаарх агуулгууд багтдаг. Аян замын тэмдэглэлүүд үүргийн хэмжээст багтах дараах агуулгууд байлаа.

- Эдийн засгийн хөгжил 41
- Дэд бүтцийн хөгжил 33
- Сайн засаглал 22
- Боловсролын чанар 14
- Бизнесийн дэмжлэг 2
- Эсэргүүцлийн жагсаал 2
- Иргэдийн орлогын бууралт 1

2. Норматив хэмжээс: Тухайн улс орны шударга ёсны нөхцөл байдлын талаарх тодорхой итгэл үнэмшил, хэм хэмжээс болон үнэ цэнийн тухай агуулгууд багтдаг. Аян замын тэмдэглэлүүдэд Хятад улс орныг шударга ёсны талаарх итгэл үнэмшил, үнэ цэнтэй холбоотойгоор дүгнэн, тодорхойлсон нь нэн ховор байлаа.

- Байгаль орчны хамгаалал 23
- Хатуу хяналт 4
- Хүний эрхийн хамгаалалт 2

3. Гоо зүйн хэмжээс: Тухайн улс орны соёл болон байгалийн үзэсгэлэнт газруудын гоо зүйн чанар болон гоо үзэсгэлэн/татах чадварын талаарх тодорхой итгэл үнэмшлийг агуулдаг. Хятадын тухай аян замын тэмдэглэлүүд түүх болон соёлын өвийг олон дурддаг бөгөөд ихэнхийг нь Монголын түүхтэй холбоотой тайлбарлажээ. Тухайлбал түүх, соёлын дурсгалт газрыг Чингис хааны түүхтэй холбосон 13, Хубилай хаан болон Юань гүрний түүхтэй холбон тайлбарласан 5 агуулга байв. Мөн энэ дунд тухайн дурсгалт газар нь ЮНЕСКО-гийн дэлхийн соёлын өвд багтсан тухай дурдсан 14 жишээ байлаа.

- Түүх, соёлын дурсгал 62
- Хоолны соёл 34
- Байгалийн үзэсгэлэн 22
- ЮНЕСКО-гийн соёлын өв 14
- Өндөр сайхан барилга 6
- Хувцасны соёл 1
- Хэл соёл 1


4. Сэтгэл хөдлөлийн хэмжээс: Улс орны тухай таашаал болон сэтгэл татагдах ерөнхий мэдрэмжийг илэрхийлдэг. Монгол сэтгүүлч, нийтлэлчид нь өмнөх гурван хэмжээст багтсан агуулгуудыг дурдахдаа дараах сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн үгсийг хамгийн олон ашигласан байна. Эдгээр нь аялагчид Хятад орны тухай чухам ямар сэтгэгдэлтэй байсныг харуулжээ.

- Гайхалтай 23
- Бахархам 16
- Гунигтай 15
- Таалагдсан 12

- Эвгүйцмээр 6
- Сонирхолтой 5
- Дотно 5
- Балмагдсан 2
- Атаархсан 2

Эдгээр хэмжээсүүдэд хамгийн олон дурдагдсан агуулгыг доор 4D загвараар үзүүлээ.

График 3. Аян замын тэмдэглэлүүд дэх Хятадын улс орны имиж



Дээрх схемээс харахад аян замын тэмдэглэлүүдээс Хятадын тухай үүргийн болон гоо зүйн хэмжээс тод илэрч байна. Хятад улс орны имижийг үүргийн талаас эдийн засаг, дэд бүтэц, сайн засаглал нь, гоо зүйн талаас түүх, соёлын дурсгал, хоолны соёл, байгалийн үзэсгэлэнт дүр төрх, харин норматив хэмжээс талаас байгаль орчныг хамгаалдаг гэсэн агуулга илэрсэн. Монголын сэтгүүлч, нийтлэлчид Хятад улсад аялаад гайхсан, бахархсан, таалагдсан сэтгэгдэлтэй үлджээ. Гэвч монголчууд хоёр орны үүх түүх, түүхийн гашуун дурсамжийг дурдахын сацуу, өөрийн улс орныг харьцуулан гунигласан сэтгэгдэлтэй байдаг аж.

Дээрх үнэлэлт, дүгнэлт нь Монголын хэвлэл мэдээлэл дэх аян замын тэмдэглэлд үндэслэсэн Хятад улс орны имижийн тухай билээ. Үүнийг бид Хятад улс өөрсдийнхөө имижийг хэрхэн авч үздэг тухай буюу улс орны өөрийн имижтэй нь харьцууллаа.

Хятадын удирдагч Ши Жинпин 2013 оны наймдугаар сард болсон National Conference on Publicity and Ideological Work хурлын үеэр Хятад улсын үндэсний имижийг тодорхойлох төрийн бодлогын үндсэн чиг хандлагыг дэвшүүлсэн байдаг. Судлаачдын зүгээс энэхүү илтгэлийг БНХАУ-ын үндэсний имижийг дотоод болон гадаад орчинд бүтээн төлөвшүүлэх төрийн албан ёсны үзэл баримтлал хэмээн үнэлдэг (Хi, 2017). Ши Жинпин уг илтгэлдээ Хятадын үндэсний имиж нь түүхийн гүн

рүү нэвтэрсэн соёлын өв, олон янзын боловч нэгдмэл угсаатны бүтэцтэй соёл иргэншлийн их хүч; улс төрийн цэвэр систем, эдийн засгийн хөгжил, соёлын дэвшил, нийгмийн тогтвортой байдал, ард түмний нэгдмэл байдлыг илэрхийлсэн Дорнын их хүч; энх тайван хөгжлийг дэмжиж, нийтлэг хөгжлийг уриалдаг, олон улсын тавцанд шударга ёсыг хамгаалж, хүний эрхэд хувь нэмэр оруулдаг хариуцлагатай их хүч; түүнчлэн илүү нээлттэй, ойр дөт, итгэл төрүүлэх социалист их хүч хэмээх цогц ойлголтод тулгуурлах ёстойг онцолсон байна (Xi, 2017).

Ши Жинпиний энэхүү үзэл баримтлалыг судлаач Жошуа Рамо задлан шинжилж, Хятадын үндэсний имижийг хэд хэдэн гол чиглэлээр системчилсэн байдаг. Тодруулбал, эдийн засгийн хөгжилд суурилсан хүчирхэг үндэсний имиж, улс төрийн тогтвортой байдлаар илэрхийлэгдэх үндэсний ардчилсан имиж, түүхэн соёлын өв болон соёлын дэвшлээр өгүүлэх иргэншсэн улсын имиж, нийгмийн хөгжлөөр дамжуулан бүрэлдэх тааламжит үндэсний имиж, экологийн соёл иргэншилд суурилсан үзэсгэлэнтэй үндэсний имиж зэрэг багтана (Ramo, 2008).

Эдгээр үзэл баримтлал, ангиллыг суурь болгон Хятадын төрөөс тодорхойлсон өөрийн үндэсний имиж болон Монголын сэтгүүлч, нийтлэлчдийн бичсэн аян замын тэмдэглэлүүд дэх Хятадын имижийг харьцуулан авч үзэхэд, төрийн бодлогын түвшинд дэвшүүлсэн имижийн бүрэлдэхүүнүүдийн дийлэнх нь Монголын хэвлэл мэдээллийн агуулгад бүрэн тусгагдаагүй байгааг харуулж байна.

Хүснэгт 12. Ши Жинпиний тодорхойлсон БНХАУ-ын имиж ба аян замын тэмдэглэл дэх имижийн агуулгын харьцуулалт.

№	Имиж	Тодорхойлолт	Аян замын тэмдэглэлүүдэд бий эсэх
1	Соёл иргэншлийн их хүч (Civilized great power)	гүний гүнд нэвтэрсэн соёлын өв (profound historical heritage) олон янзын бөгөөд нэгдмэл угсаатны бүлгүүд (diverse yet unified ethnic group) зохистой бөгөөд олон янзын соёл (harmonious and diverse culture)	+

2	Дорнын их хүч (Eastern great power)	улс төрийн цэвэр систем (clean political system)	+
		эдийн засгийн хөгжил (economic development)	+
		соёлын дэвшил (cultural prosperity)	-
		нийгмийн тогтвортой байдал (social stability)	-
		ард түмний нэгдмэл байдал (people's unity)	-
		үзэсгэлэнтэй газар нутаг (beautiful landscapes)	+
3	Хариуцлагатай их хүч (Responsible great power)	энхтайван хөгжлийг дэмждэг (upholds peaceful development)	-
		нийтлэг хөгжлийг уриалдаг (promotes common development)	-
		олон улсын тавцанд үнэнч шударга ёсыг хамгаалдаг (safeguards international fairness and justice)	-
		хүний эрхэд хувь нэмрээ оруулдаг (contributes to humanity)	-
4	Социалист их хүч (Socialist great power)	илүү нээлттэй (more open)	-
		илүү ойр дөг (more approachable)	-
		илүү итгэл найдвараар дүүрэн (full of hope)	-
		амьдралын эрч хүчээр дүүрэн (full of vitality)	-

Дээрх хүснэгтээс харахад Хятадын улс орны өөрийн имижид багтах ёстой гэж үзсэн 17 агуулгаас 4 нь буюу 23.5 хувь нь түүвэрт хамрагдсан монгол сэтгүүлч, нийтлэлчдийн аян замын тэмдэглэл дэх имижид агуулагдаж байна. Үлдсэн 13 агуулга буюу 76.5 хувь нь бүрхэг эсвэл огт байхгүй гэж дүгнэлээ. Түүнчлэн Ши Жинпиний Хятад улс орны тухай имиж нь их зовлон зүдгүүрийг давж туулсан хятад ард түмний амжилтын түүхээр дамих ёстой гэж үзэж буй санаа, зорилго аян замын тэмдэглэлүүдийн агуулгад байгаагүй. Хятад хүнийг ямар нийгмийн бүлэг, нас, хүйсээр голчлон тодорхойлох төлөөлөл нь бүрхэг, хятад хүний тухай тодорхойлолт-имиж нь ч тодорхой бус байлаа. Тиймд Хятадын удирдагч Ши Жинпины зорьж буй Хятад улс орны өөрийн имиж, монгол сэтгүүлч, нийтлэгчдийн бүтээн, дамжуулж буй имиж нь хоорондоо зөрүүтэй байна гэж дүгнэлээ.

Дүгнэлт, хэлэлцүүлэг: Монголын өдөр тутмын сонин болон вэб сайт, блогуудад гарсан аян замын тэмдэглэлийн тал нь гаднын улс орнуудын

тухай бөгөөд үүнд Хятадын тухай тэмдэглэлүүд давамгайл байр суурь эзэлдэг байна. 1990 оноос хоёр улсын гадаад харилцаа нээлттэй болж, шинэ шатанд гарсан. 1990 оноос хойш Монголын өдөр тутмын сонин, мэдээллийн вэб сайт болон блогуудад гарсан аян замын тэмдэглэлүүд нь дараах онцлогтой байна.

Хятад хүмүүс хэрхэн аж төрж буй талаарх жишээ, баримт нэн ховор, нийгмийн амьдралын гүнд нь орж сурвалжилсан, тэмдэглэсэн зүйл цөөн байна. Харин хятад орны түүх, соёлын дурсгалт газрууд болон эдийн засгийн хөгжлийн тухай агуулга хамгийн тод илэрч байна.

Монгол сэтгүүлч, нийтлэлчдийн хувьд БНХАУ-д аялаад гайхан бахархаж, таатай сэтгэгдэл төрснөө илэрхийлсэн ч хоёр улс орны гашуун түүх, Монгол Улсын алдсан боломжийн талаар сэтгэл дундуур байдаг нь аян замын тэмдэглэлүүдээс харагдлаа. Монголын аян замын тэмдэглэлүүд БНХАУ-ыг бодит ахуй, хот байгуулалт, эдийн засгийн өсөлтөөр дамжуулан танин мэдэхүйн өнцгөөс дүрсэлж буй ч хятад хүний нийгмийн бодит төлөөлөл, үнэт зүйл, үнэлэмж хангалтгүй байна. Мөн Хятадын төрөөс тодорхойлсон үндэсний имижийн зарим бүрэлдэхүүн Монголын хэвлэлд бүрэн тусгагдаагүй нь төрийн бодлогын имиж ба гадаад орчинд дамжсан имиж хоорондын зөрүүг илтгэж байна.

Эшлэл:

- Xi, J. (2017). *Excerpts from Xi Jinping's discourses on socialist cultural development*. Foreign Languages Press, Beijing.
- Ramo, J. (2008). *China through the eyes of foreign scholars*. Social Sciences Academic Press, Beijing.
- Anholt, S. (2010). *Places: Identity, image and reputation*. Palgrave Macmillan, London.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Баярмаа Б. (2024). *Монголын хэвлэл мэдээллийн эрх зүйн орчны судалгаа*. Дис.
- Болд-Эрдэнэ Б. (2020). Монголын олон улсын сэтгүүл зүйд хөрш орнуудын талаар тусгаж байгаа нь. *Сэтгүүл зүй*. №21/540.
- Наранбаатар Б. (2017). Улс орны имиж төлөвшилд ОНМХ-ийн гүйцэтгэх үүрэг. *Сэтгүүл зүй*.
- Норовсүрэн Л. (2025). *Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь*. УБ.
- Anholt, S. 2010. *Places: Identity, image and reputation*. Palgrave Macmillan, London.

Ramo, J. 2008. *China through the eyes of foreign scholars*. Social Sciences Academic Press, Beijing.

Xi, J. 2017. *Excerpts from Xi Jinping's discourses on socialist cultural development*. Foreign Languages Press, Beijing.

Summary

This study examines the image of China represented in Mongolian travel narratives published in print and online media between 1992 and 2024. Using content analysis, sentiment analysis, and the 4D nation image model, 95 travel articles were analyzed. The findings indicate that China's image is primarily constructed through functional and aesthetic dimensions, while normative and political values are underrepresented. The study reveals a noticeable gap between China's self-defined national image and the image conveyed by Mongolian journalists.

Keywords: nation image, travel writing, China, Mongolian media, content analysis